



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 08 сарын 23 өдөр

Дугаар A/116

Ховд

┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** ─┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжих Сумдын Эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн компьютер тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: М.Одончимэг - Мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн

Н.Алтангэрэл - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Х.Эрдэнэцэцэг - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга Э.Цолмон - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Н.Ганзориг/-д даалгасугай.

3. Дээрхи төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн хадгалахыг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Э.Цолмон/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД